



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ГОТОВЫН БАТБАЯР ТАНАА

2020.09.03 № СГА-2020/06-14-70
танай _____-ны № _____-т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Готовын Батбаярын мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Г.Батбаяр нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050” холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Г.Батбаярын Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Г.Батбаярын мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.


Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГОТОВЫН БАТБАЯРЫН МӨРИЙН ХӨТЕЛБӨР**



Нэг. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж ажиллана.

- 1.1 Орон нутгаас сонгогдсон нам эвслийн төлөөлөгчид болон төрийн албан хаагчидтай хамтран ажиллаж сум, орон нутгаас гарч буй тогтоол, шийдвэр оновчтой зөв гарагад өөрийн мэдлэг, чадварын хүрээнд дэмжлэг үзүүлнэ.
- 1.2 Сум, багийн удирдлага төрийн үйлчилгээний албан хаагчид болон төрийн бус байгууллага хувийн хэвшлийн албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангаж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.
- 1.3 Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан, төсөв санхүүгийн хөрөнгийг тодорхой үр дүнтэй үйл ажиллагаа, бүтээн байгуулалтад зарцуулж буй эсэхэд тавих олон нийтийн хяналтыг сайжруулна.
- 1.4 Байгаль орчноо хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, зэрлэг ан амьтан, байгалийн баялаг болсон самар, жимс жимсгэнэ бусад байгалийн баялгаа хамгаалахад малчид болон орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 1.5 Ашигт малтмалын ордыг тусгай зөвшөөрөл эзэмших баримт бичигт тусгагдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй эсэхэд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллана.

Хоёр. Мал аж ахуй, газар тариалан, төмс хүнсний ногоо тарьж хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжихэд төрийн бодлогыг уялдуулан ажиллана.

- 2.1 Төрөөс малчдын талаар авч хэрэгжүүлж байгаа бодлогыг дэмжиж, сум орон нутгийн малчдад тулгамдсан нийтлэг асуудлыг шийдвэрлэх ажлыг холбогдох байгууллагад уламжлан, хамтран хэрэгжүүлнэ.
- 2.2 Малчин өрх бүрийн санал санаачилга, үр бүтээлтэй сайн ажлыг дэмжин, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх асуудлыг дэмжиж, холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 2.3 Мал аж ахуйн удмын санг сайжруулах, үржил селекцийн үйл ажиллагааг стандартын дагуу шинжлэх ухааны болон малчин хүний амьдралын ухааныг хослуулан мал сүргийн үүлдэрлэг чанарыг сайжруулах ажлыг орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулна.
- 2.4 Газар тариалан, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний мод ургуулан үр шимийг нь хүртэж, аж амьдралаа дээшлүүлж байгаа иргэдэд төрийн бодлоготой уялдуулан сум орон нутгийн хөгжилд нийцсэн хөтөлбөр боловсруулан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.5 Газар тариалан эрхлэгчид болон малчин өрхийн хоорондын малын бэлчээр,

хадлангийн талбайн зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

- 2.6 Сумын ногоочдын холбооны үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.7 Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдийн сум орон нутгийн хөгжил дэвшилд үзүүлэх нөлөөллийг судалж, хөнгөлөлттэй болон урт хугацааны зээлд хамруулах асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллана.

Гурав. Иргэн таны төрийн төлөөлөл учир хүлээсэн үүргээ ухамсарлан, иргэн танд ил тод шударга төрийн үйлчилгээг үзүүлэн ажиллана.

- 3.1 Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах таатай орчныг бүрдүүлэх боломжийг судалж, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.
- 3.2 Төрийн ажлыг түргэн, шуурхай явуулах, албан тушаалын томилгоог улс төрөөс ангид байхыг дэмжинэ.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:

/Г.Батбаяр/